



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 89

Улаанбаатар хот

Тусгай зориулалтаар 2024 онд агнах,
барих агнуурын амьтны тоо хэмжээг
тогтоох тухай

Засгийн газрын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Амьтны тухай хуулийн 26.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1.Тусгай зориулалтаар 2024 онд агнах амьтдын тоо хэмжээг 1 дүгээр хавсралт, барих загасны тоо хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Тусгай зориулалтын ангийн дуудлага худалдааг тухайн жилд агнах, барих амьтны тоо хэмжээний дээд хязгаарт багтаан, холбогдох хуульд нийцүүлэн зохион байгуулахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Б.БАТ-ЭРДЭНЭ

Засгийн газрын 2024 оны 03 дугаар
сарын 06-ны өдрийн 89 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР 2024 ОНД АГНАХ АМЬТДЫН ТОО ХЭМЖЭЭ

№	Аймгуудын нэрс	Угалз	Тэх	Халиун буга	Цагаан зээр	Бор гөрөөс	Зэрлэг гахай	Саарал чоно	Хүрэн баавгай	Агнуурын шувуу
1.	Баян-Өлгий	14	24	6			9			
2.	Баянхонгор	6	21	3						
3.	Булган			2						
4.	Говьсүмбэр	1			10					
5.	Дорноговь	7								
6.	Дорнод			2	50	2				
7.	Дундговь	2	4		20					
8.	Завхан	1	4	8	10			6		
9.	Өвөрхангай	5	8	3		2		2		
10.	Өмнөговь	9	18							
11.	Сэлэнгэ			5					4	
12.	Төв	7		11	22			3		
13.	Увс	7	9	14						
14.	Ховд	7	27				12			
15.	Хөвсгөл			4		4				
16.	Хэнтий	4		5	30					50
	НИЙТ	70	115	63	142	8	21	11	4	50

----o0o----

Засгийн газрын 2024 оны 03 дугаар
сарын 06-ны өдрийн 89 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР 2024 ОНД БАРИХ
ЗАГАСНЫ ТОО ХЭМЖЭЭ

№	Аймаг	Тул загас (бариад тавих)	Бусад загас
1.	Хэнтий	90	900
2.	Хөвсгөл	405	3000
3.	Булган	30	300
	НИЙТ	525	4200

----o0o----